НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 29 өдөр Дугаар А/74 Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 6.2 дахь хэсэг, Дүрэм шинэчлэн батлах тухай" нийслэлийн Засаг даргын 2023 оны А/795 дугаар захирамжаар шинэчлэн батлагдсан нийслэлийн "Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалган тогтоох, төрийн албан хаагчийн ёс зүйн сахилга хариуцлагын чиглэлээр сургалт зохион явуулах үүрэг бүхий Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ёс зүйн дэд хорооны дарга:	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд	Төслийн хэрэгжилт, зохицуулалтын хэлтсийн дарга
	Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн
	Хууль эрхзүй, гэрээ хариуцсан ажилтан
Нарийн бичгийн дарга:	Хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

2.Албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, урьдчилан сэргийлэх, ёс зүйн сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой үр дүнтэй ажлуудыг зохион байгуулан, хэрэгжилтийг ханган, үр дүнг тайлагнаж ажиллахыг Ёс зүйн дэд хороо (Д.Сайнхүү)-д үүрэг болгосугай.

3. Холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шударга, оновчтой, үнэн бодит дүгнэлт гаргах, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журмыг мөрдлөг болгон ажиллахыг Ёс зүйн дэд хороо (Д.сайнхүү)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2022 оны А/75 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА Б.ДАВААНЯМ

2150500281

D:\2023 он\Тушаал\А тушаал\2023-74 Ёс зүйн хороо байгуулах тухай.docx